

ДЭЛХИЙД ТАНИГДСАН ЭРДЭМТЭН

*Б. Энхтүвшин**

Монголын түүх бичлэгийн баялаг өв уламжлал, Монгол төрийн гадаад харилцааны туршлага, сургамжинд тулгуурлан гадаад орон судлалын бие даасан эрдэм шинжилгээний байгууллага болох олон улс судлалын хүрээлэн үүсч байгуулагдаад нэгэнт 40 жилийг ардаа үлдээж, ахин дэвшсээр байна.

Анх ШУА-ийн Ази-Африкийн хэлтэс нэртэй тулгын чулуугаа тулж улмаар Дорнодахины судлалаас олон улс судлал хэмээх шинжлэх ухааны шинэ салбар болон өргөжин тэлэв. Тус хүрээлэнд Монголын тэргүүлэх нэрт эрдэмтэд, дэлхийд данстай Б.Ширэндэв, Ш.Бира, Ч.Далай, Н.Ишжамц, Л.Жамсран, Г.Сүхбаатар, академич Б.Лхамсүрэн, Б.Балдоо нарын олон олон эрдэмд гэгээрсэн мэргид ажиллаж байсан бахархал бий. Тэдний нэг бол Монгол Улсын Шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн, шинжлэх ухааны доктор, профессор, Олон улсын Мэдээллийн академийн жинхэнэ гишүүн (академич), ШУА-ийн Олон Улс Судлалын хүрээлэнгийн захирал Гүүш овогт Лувсангийн Хайсандай яахын аргагүй мөн.

Тэгээд ч Дорнодахины “жаахан” Хайсандай, дэлхийд танигдсан “лут эрдэмтэн”, Олон Улс судлалын Хайсандай, Орчлонд танигдсан “эрдмийн жинчин” гэж түүний төрсөн нутаг Ховд аймгийн Мөст сумын сургуулийн анд нөхөд нь төдийгүй олноороо ярилцдаг юм байна лээ.

НҮБ-ын бүрэн эрхт гишүүн Монгол Улсын олон улсын байр, харилцаа, хамтын ажиллагаа өргөжиж байсан өнгөрсөн зууны 60-аад оны дундуур буюу 1965 онд Москва хотноо Гадаад харилцааны дээд сургууль төгссөн Л.Хайсандай, Монголыг гадаадад таниулах цонх болсон “МОНЦАМЭ” агентлагаас ажил хөдөлмөрийн гараагаа эхэлжээ. НҮБ-ын албан ёсны гол хэл-орос, испани хэл эзэмшсэн, олон улсын харилцааны түүхч, орчуулагч тэрбээр 1966-1974 онд Монголын оюутны холбооны орлогч дарга, Монголын Залуучуудын Төв Хорооны гадаад харилцааны хэлтсийн эрхлэгчийн албыг нэр төртэй хашиж байсныг “Монголын Залуучууд” зэрэг нэвтэрхий тольд тэмдэглэн үлдээжээ. Залуучуудын байгууллагын гадаад харилцааг эрхлэн хариуцаж байсан он жилүүдэд дэлхийн залуучууд, оюутны удаа дараагийн их наадам, чуулга-уулзалтуудад улс орноо төлөөлөн оролцохын хамт олон улсын залуу үеийнхний орчин үеийн хөдөлгөөн, энх тайван, хөгжил дэвшил, улс орнуудын найрамдал, хамтын ажиллагааны талаар хоёр товхимол, 120 гаруй өгүүлэл-нийтлэл, тэмдэглэл бичиж хэвлүүлсэн байна. Тэрбээр залуучууд, оюутны байгууллагын шугамаар дэлхийн хэмжээнд нүд тайлж олон оронд албан ажил хэргээр айлчлан очиж байсны хүрээнд НҮБ-ын ерөнхий нарийн

* Б. Энхтүвшин - ШУА-ийн Ерөнхийлөгч, академич

бичгийн дарга У.Тан, Кубын Фидель Кастро, Че Гевара, Алжирын Бен Белла, Чилийн Сальвадар Альенде нарын зэрэг дэлхийн хэмжээний хүмүүстэй нүүр учирч, олон улсын янз бүрийн арга ажиллагаанд биечлэн оролцож явжээ. Энэ бүхэн нь түүнийг эрдэм судлалын замд сэтгэл шулуудан орж, тэр дундаа Дорнодахины судлалын хүрээлэнгийн хөрөнгөтөн ба хөгжиж буй орнуудын тасагт эрдэм шинжилгээний ажил хийх суурь дэвсгэр нь болжээ.

Л.Хайсандай 1980 онд “Монгол ба хөгжиж байгаа орнуудын харилцаа (1955-1980) “ сэдвээр дэд эрдэмтний зэрэг амжилттай хамгаалсан юм. Энэ нь Монголын гадаад харилцаа хөгжиж буй орон судлалын тухайд манайдаа анхны бөгөөд дорвилог бүтээлийн нэг яах аргагүй мөн юм. Тухайн жилдээ “Монгол Улс ба Хөгжиж байгаа орнууд (1955-1980) “ хэмээх орос хэлээр хэвлүүлсэн нэгэн сэдэвт эрдмийн бүтээлдээ зохиогч Монгол Улс Ази-Африкийн шинэ тулгар чөлөөлөгдсөн орнуудыг тухай бүр хүлээн зөвшөөрч, тэдгээртэй нөхөрсөг харилцаа тогтоож ирсэн үйл явцыг тухайн цаг үетэй нь нягт уялдуулан, онцлог шинж, чиг хандлагыг анх түрүүн эрдэм шинжилгээний үүднээс тоймлон үзжээ.

Л.Хайсандайн бүтээлд “Монгол Улсын тэр үед шинээр тусгаар тогтносон эдгээр улс орны тухайд баримталсан бодлого, байр суурь нь өөрөө дэлхий дахинд де-юре хүлээн зөвшөөрөгдөх үйл явцыг эрчимтэй өрнүүлж, улмаар НҮБ-ын бүрэн эрхт гишүүнээр элсэн орох, олон улсын нэр хүндээ өсгөн бэхжүүлэхэд ихээхэн тус дөхөм болсон гэсэн бодитой шинэлэг дүгнэлт хийжээ. 1960-аад оны үеэс эхлэн Монгол Улсыг феодализмаас капиталист нийгмийг алгасан социализмд дэвшин орсон “анхны социалист” орон хэмээн тунхагласан үзэл номлол, суртал үнэмлэхүй ноёрхож байсан чухамхүү тэр үед шинэ тутам хөгжиж байгаа орон судлалаар хийсэн судалгаандаа тулгуурлан, “Монгол Улс бол хөгжиж байгаа орон мөн” гэсэн шинжлэх ухааны үндэслэл бүхий шинэ томъёоллыг анх дэвшүүлэн гаргаж, манай улс НҮБ-ын Ази-Африкийн бүлэг, хөгжиж байгаа орнуудыг нэгтгэсэн “77-ийн бүлэг”, улмаар эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнд элсэн орж, хамтран ажиллах явдал олон талын ихээхэн ач холбогдолтой гэсэн тодорхой санаа дэвшүүлж, төр, засгийн бодлого, шийдвэрт бүүр тэр үед тусгуулж чадсанаар өнөөдөр бүрэн биелэлээ олсон байна. Энэ нь эрдэмтэн Л.Хайсандайн эрдэм шинжилгээний ажлын чухал үр дүн мөн” гэж түүхийн шинжлэх ухааны доктор Ш.Сандаг өндөр үнэлжээ.

Тэрээр 1999 онд “ Монгол Улсын үндэсний эрх ашиг ба гадаад бодлого: онол практикийн асуудал” сэдвээр шинжлэх ухааны (Sc.D) докторын зэрэг хамгаалсан байна. Л.Хайсандайн доктор (Ph.D), шинжлэх ухааны докторын (Sc.D) ажлыг хоёуланг Монголын шинжлэх ухааны ноён оргилын нэг, академич Б.Ширэндэв агсан удирдсан нь түүний оюуны бярыг үнэлсэн хэрэг юм.

Лувсангийн Хайсандайн “Монгол Улсын үндэсний эрх ашиг ба гадаад бодлого: онол, практикийн асуудал” бүтээл нь Монгол Улсад энэ чиглэлээр судалж туурвисан анхны томоохон бүтээл болсны хувьд хөгжлийн стратеги, түүх- олон улс судлаачдын анхаарлыг зүй ёсоор татдаг юм. Эл бүтээлийн үнэ цэнийг олон эрдэмтэн онцлон тэмдэглэсний дотроос түүхийн шинжлэх ухааны доктор Н.Дангаасүрэн: “Монгол Улсын гадаад харилцааг үндэсний эрх ашгийн үүднээс онол, арга зүйн шинэ баримтлал, чиглэлээр судалсанд Л.Хайсандайн энэ бүтээлийн шинэлэг тал тодорно. Энэ шинэлэг тал бол улс төр судлал, түүх судлалыг уялдуулан Монгол Улсын үндэсний эрх ашгийн түүхэн үйл явцыг үнэлж цэгнэхэд оршино. Монгол Улсын үндэсний эрх ашигт багтах харилцан уялдсан асуудлыг онолын хувьд гаргаж тавьсан нь маш сонирхолтой болжээ” хэмээн үнэлэлт, дүгнэлт өгчээ.

Монгол Улсын үндэсний эрх ашиг гэдэг бол нийт хүн төрөлхтний эрх ашгийн тодорхой тусгал, олон улсын хууль зүйн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд энэ асуудал нь олон улсын харилцааны шударга, тэгш, харилцан хүндэтгэсэн хэм хэмжээнд байснаар дэлхийн нийт улс гүрнүүдийн хоорондын найрсаг харилцаа хамтын ажиллагаа хөгжих таатай нөхцөл болдог. Монголын тусгаар тогтнол аюулгүй байдал, хөгжлийн гарц бол түүний зохиол бүтээлийн мөн чанар байдаг. Тэрбээр 1999 онд академич Б.Балдоо, доктор (Sc.D) С.Дамдинсүрэнгийн хамт “Монголын тусгаар тогтнол ба Орос, Хятадын хүчин зүйлс” /20.4хх/ хэмээх зохиол бичсэн нь 2006 онд “Монголын ХХ зууны шилдэг бүтээл”-ийн нэг болон шалгарч, “Монголын ШУ-ны шилдэг бүтээлийн дээжис - 99” ботид хэвлэгдэх эрхийн батламж авчээ.

Доктор, профессор Л. Хайсандайн зохиол бүтээлд Монгол Улсынхаа аюулгүй байдлыг дэлхийн улс төрийн олон талт, эдийн засгийн даяаршлын олон улсын орчинд хэрхэн хадгалж, бэхжүүлэхийг чухалчлан үзсэн байдаг. Энэ асуудлыг судлах нь эрдэмтэн хүний хувьд хамгийн гол асуудал мөн гэдэг үзэл бодлоо тэрээр байнга илэрхийлдэг. Энх тайван ба хөгжил, аюулгүй байдал ба хөгжил бол орчин үеийн бүрэн эрхт Монгол Улсын хүн төрөлхтний өмнө хүлээсэн 2 том үүрэг хариуцлага мөн гэдгийг Л.Хайсандай 2008 онд хятад хэлээр хэвлүүлсэн, одоо япон хэлээр нийтлэгдэж буй “Монгол Улсын аюулгүй байдлын стратегийн асуудал: судалгаа, үзэл бодол” гэдэг судалгааны томоохон бүтээлдээ онцлон дурьдсан байна.

Анх удаа гадаад хэлээр хэвлэгдсэн эл бүтээл нь нийт 11 бүлэг, 36 зүйлээс бүрэлдсэн томоохон хэмжээний зохиол болжээ. Зохиогч Монгол Улсын аюулгүй байдлыг тухайлан эдийн засаг, экологи, хүнс, хүн ам, удмын сан, үндэсний соёл, зан заншил, хүний эрх, эрх чөлөө, цэрэг, улс төрийн тогтолцоо зэрэг бүх талыг хамран хооронд нь уялдуулан цогцоор задлан шинжлэх оролдлого хийж, өнөө болон

хойшид аюулгүй байдлын хамаатай тулгамдсан асуудалд үнэлгээ эргэцүүлэл хийж, тодорхой санал дэвшүүлсэн онол, практикийн ач холбогдолтой бүтээл болсныг эрдэмтэд онцлон тэмдэглэсэн байна. Тэгээд ч уг бүтээл БСШУЯ-ны хэмжээнд шинжлэх ухааны 2008 оны шилдэг бүтээлийн байрт шалгарчээ.

Эрдэмтэн судлаач Л.Хайсандайн улс эх орондоо 44 жил, түүний дотроос эрдмийн ажил хийсэн 35 жил, үүнээс хүрээлэнгийн захирлын алба хашсан 10 жилийн амьдрал, үйлс, нэр төр, гавъяа зүтгэл нь гадаад харилцаа, гадаад орон судлал, олон улсын харилцаатай алив нэг сэжмээр нягт холбоотой юм. Түүний эрдмийн бүтээл туурвилууд ч энэ чиглэлээр голлон нийтлэгдсэн байна.

Л.Хайсандайн “Эрдмийн бүтээлийн товчоон”-оос харахад, эрдэм шинжилгээний ном зохиол 12, эрдэм шинжилгээний хамтын бүтээл 8, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл 160 гаруйг нийтлүүлжээ. Үүнээс ОХУ, БНХАУ, БНСУ, Тайвань, Турк, Энэтхэг, Япон зэрэг оронд орос, хятад, англи, испани, солонгос, польш хэлээр хэвлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүлэл илтгэл 40 гаруй, хянан тохиолдуулсан ном зохиол 25 гэх мэт эрдэм судлалын бүтээлийн жагсаалт хөврөл нь түүний хэр өргөн цар хүрээтэй, дэлхийд данстай эрдэмтэн болохын нэгээхэн баталгаа гэлтэй.

Л.Хайсандай эрдмийн ажилд үргэлж дэвшиж дээшилж явсан замналтай. Тухайлвал 1974 оноос Дорнодахин судлалын хүрээлэнд эхлээд ЭША, дараа нь 1986-1990 онд эрдэмтэн нарийн бичгийн дарга, 1990-1994 онд Москвад ОХУ-ын ШУА-ийн Дорнодахины хүрээлэнд эрдэм шинжилгээний ахлах ажилтан, 1994-1999 онд Монголын ШУА-ийн Зүүн хойд Ази судлалын төвд эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, сэтгүүлийн эрхлэгч, 1999 оны эцсээр Зүүн хойд Ази судлалын төв, Түүхийн хүрээлэнгийн Олон улс судлалын төв хоёрыг нэгтгэж Олон улс судлалын хүрээлэн хэмээн өөрчлөн байгуулахад мөн тэргүүлэх ажилтнаар ажиллаж байгаад 2000 оноос тус хүрээлэнгийн захирлаар томилогдон ажиллаж байгаа юм.

Энэ хугацаанд тус хүрээлэн бүтэц, зохион байгуулалт, боловсон хүчин, эрдэм шинжилгээний цар хүрээ, далайц, чадамж, бүтээл туурвилын хувьд үлэмж өсөн бэхжиж, дотоод, гадаадад хүлээн зөвшөөрөгдсөн, нэр хүнд бүхий эрдмийн байгууллага болж чадсаныг онцлон тэмдэглэе. Энэ бүхнээс харахад Л.Хайсандай нь зөвхөн эрдэмтэн төдийгүй эрдмийн ажлыг чадмаг удирдан зохион байгуулагч гэдгээ бас харуулсан гэж хэлж болно. Хоёр, гуравхан тасагтай 22, 23 эрдэм шинжилгээний ажилтантай ихэнх нь дундаас дээш насны хүмүүс байсан хүрээлэнг ажил үйлсийн нь хувьд өргөтгөн бэхжүүлж, ам бүлийн нь хувьд өсгөн нэмсээр өнөөдрийн байдлаар Орос судлал, Хятад судлалын гэсэн 2 үндсэн салбар, Япон, Америк, Солонгос ба Зүүн Ази, Европ, Төв Ази

судлал гэсэн 5 сектортой, нийт 37 эрдэм шинжилгээний ажилтантай, үүнээс ШУ-ны доктор 4, боловсролын доктор 12, магистр 11, ЭША 12-той болгосон хийгээд тэдгээрийн 70 шахам хувь нь мэргэжлийн шинэ залуу хүмүүсээр бүрэлдсэн байна. Энэ бол бага биш амжилт. Сүүлийн арваад жилийн туршид энэ хүрээлэнгийн эрдмийн хамт олон Монголын гадаад харилцаа, гадаад орон судлалын чиглэлээр нийт 36 ном зохиол, 400 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл бичиж дотоод, гадаадад нийтлүүлэн олны хүртээл болгосон гэсэн дүн мэдээ гарсан байгаа. Үүний хамт доктор Л.Хайсандайн санаачлага, идэвхитэй оролцоотойгоор Герман судлал, Энэтхэг судлалын төвүүдийг шинээр үүсгэн байгуулж, үйл ажиллагааг нь идэвхижүүлэн явуулж байна.

Түүнчлэн доктор Л.Хайсандай хүрээлэнгийн тогтмол хэвлэлийг үлэмж анхааран үзэж, үндсэн хэвлэл “Олон Улс Судлал” сэтгүүлийн гаргалтыг тогтмолжуулах, нийтийн захиалгад оруулсанаас гадна Хятад судлалаар “Өнөөгийн Хятад”, Орос судлалаар “Эв мод”, Герман судлалаар “Герман: судлагаа, мэдээлэл”, Энэтхэг судлалаар “Монгол дахь Энэтхэг судлал” сэтгүүлийг тухайн улсын ЭСЯ-ны санхүүгийн дэмжлэгтэйгээр хэвлэн нийтлүүлж ирсэн нь нэг чухал ололт мөн. Тус хүрээлэн ОХУ, БНХАУ, АНУ, Япон, БНСУ, ХБНГУ зэрэг орны эрдэм шинжилгээний 10 гаруй байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээр байгуулан хамтран ажилладаг байна. Тэдгээр байгууллагад эрдэм шинжилгээний залуу ажилтнуудаа судалгааны арга барил эзэмшүүлэх, мэдлэг мэргэжлийг нь дээшлүүлэх чиглэлээр илгээх ажлыг зохион байгуулах талаар байнга хүчин чармайлт гаргаж байна.

Мөн Орос, Хятад, АНУ, Япон судлалаар эрдэм шинжилгээний 20 шахам бага хурал, симпозиумыг Үндэсний Аюулгүй байдлын зөвлөл, Гадаад Харилцааны Яам болон дээрх улсуудын судалгааны байгууллагууд, Элчин Сайдын Яамдтай хамтран зохион байгуулсан нь зохих үр дүнтэй арга хэмжээ болсон байна. Энд ганц жишээ дурдахад, захирал Л.Хайсандайн санаачлагаар хоёр их хөршийн эрдэм шинжилгээний холбоо харилцаатай ажилладаг эрдмийн байгууллагатай хамтран гурван орны эрдэмтдийн форумыг тодорхой сэдвээр тус тусын нийслэлд ээлжлэн хийж байхаар хэлэлцэн тохиролцсон явдал байлаа. Үүний дагуу хөрш гурван улсын эрдэмтдийн анхдугаар форумыг “Монгол, Орос, Хятад: XXI зуунд хөгжлийн төлөө хамтдаа” гэсэн сэдвээр Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор Улаанбаатар хотноо 2008 оны 6 дугаар сард амжилттай зохион байгуулжээ. Хоёрдугаар форум нь энэ 2009 оны 6 дугаар сард Бээжин хотноо болсон бөгөөд гуравдугаарыг нь Москвад ирэх 2010 оны тав- зургадугаар сард зохион явуулах гэж байна. Энэ бол захирал, доктор Л.Хайсандайн нэр хүнд, хүчин зүтгэл, идэвхи санаачлагатай шууд холбоотой нь мэдээж бөлгөө.

Энэ хугацаанд хүрээлэнгийн эрдэм шинжилгээний 4 ажилтан (М.Хурметхан, О.Батсайхан, Р.Жамц, Ц.Баатар) ШУ-ны докторын, 4 ажилтан (Н.Төмөр, Ч.Батцэцэг, А.Нямдолжин, Д.Зоригт) боловсролын докторын зэргийг амжилттай хамгаалсан төдийгүй ОХУ, БНХАУ, Япон, БНСУ, Тайванаас ирж тус хүрээлэнгийн эрдмийн зэрэг хамгаалуулах зөвлөл дээр зохиол бүтээлээ шүүн хэлэлцүүлж шинжлэх ухааны ба боловсролын докторын зэрэг хамгаалсан зэрэг нийцтэй үйл ажлуудынх нь тухай дурдахад хангалттай буй заа.

Тийнхүү доктор Л.Хайсандай манай оронд олон улс судлалыг хөгжүүлэх, шинэ залуу боловсон хүчнээр бэхжүүлэх, эрдмийн хамт олныг бүрэлдүүлж төлөвшүүлэх үйлсэд бодитой хувь нэмрээ оруулж ирэв.

Манай орны олон улс судлалд гарсан нэг шинэлэг зүйл бол доктор Л.Хайсандайн санаачлагаар монголын ба гадаадын нэртэй эрдэмтэд, дипломатуудад “Хүндэт доктор”-ын өргөмжлөл, судалгааны профессор (Research professor) цол олгох дэг журмыг боловсруулж, тэр дагуу олон хүнд тухайн өргөмжлөлийг ёслол төгөлдөр гардуулан өгч, судалгааны профессор цолыг нь олгосоор иржээ. Тухайлбал, Хүндэт докторын өргөмжлөлийг Роберт Скалагино (АНУ), Р.Рыбаков (ОХУ), Б.Мацуда (Япон), Хуан Жакуй (БНХАУ), Ж.Бейкер (АНУ), М.Ханада (Япон), П.Мета (Энэтхэг) болон Монголын нэр алдартай хүмүүс Л.Түдэв, Б.Жаргалсайхан, Ш.Бира, Ц.Гомбосүрэн, С.Дамбадаржаа нарт гардуулсан бөгөөд Судалгааны профессор цолыг эрдэмтэн судлаач Ц.Хандсүрэн, Ж.Энхсайхан, С.Дамдинсүрэн, Ц.Батбаяр, М.Хурметхан, Д.Цахилгаан, Д.Билэгт, Ц.Баатар, Н.Төмөрхүлэг, Н.Дугарсүрэн, Г.Төмөрчулуун, Г.Мэнд-Ооёо нарын зэрэг хүмүүст хүртээжээ.

Тийнхүү эрдэмтэн Л. Хайсандай Монгол Улсын гадаад бодлого, олон улсын харилцааны түүхийг бичилцэж, өөрийн оронд Орос судлал, Хятад судлал, Япон судлал, Герман судлал, Энэтхэг судлал зэрэг олон улс судлалын шинэ салбарыг үүсгэн хөгжүүлэхэд гар бие оролцож, удирдан зохион байгуулж, залгамж халаа шинэ залуу олон эрдэмтэн төрүүлж, эрдмийн ажлыг нь удирдсан зэрэг нөр их хөдөлмөр зүтгэлийг үнэлж, 2005 онд Монгол Улсын “Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн” цол хүртээсэн ба мөн “Алтан гадас” одон, Их Монгол улсын 800 жилийн ойн хүндэт медаль, ЭШ-ний тэргүүний ажилтан цолыг тус тус олгожээ. Түүнчлэн “Монголын алтан ном”, “Монголын алдар гавьяатнууд” зэрэг нэвтэрхий толь ботиудад түүний ажил үйл, эрдмийн бүтээлийн тухай дуурсган бичиж нийтэлжээ.

Эдүгээ жаргалтай дэлгэр 70 насны сүүдэр зэрэгцэж буй, дэлхийг таньж, дэлхийд танигдсан эгэл нэгэн эрдэмтэн Л.Хайсандай гуайдаа эрүүл энх, аз жаргалыг хүсэж, эрдмийн бүтээл, номын буянгаа өргөн олондоо хүртээж явах ариун үйлст тань өөдрөг байхын өлзий учралт ерөөлийг өргөн дэвшүүлж байна.